Төлөвлөгөөг баталсан: ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГА ..................... Л.БЯМБАСҮРЭН

(гарын үсэг)

.....................

(огноо)

Төлөвлөгөө боловсруулсан: НЭГЖИЙН ДАРГА

БУЛГАН АЙМАГ ДАХЬ ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН ХЭЛТСИЙН ДАРГА ..................... Б.АРИУНБОЛД

(гарын үсэг)

2024.03.07

(огноо)

# БУЛГАН АЙМАГ ДАХЬ ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН ХЭЛТСИЙН 2024 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | 2024 онд хүрэх зорилтот түвшин | Хугацаа (I-IV улирал) | Хариуцах албан хаагч |
|---|---|---|---|---|---|---|---|
| **Зорилго 1.** Даатгуулагчийн эрэлт хэрэгцээ, шаардлагад нийцсэн цахим тогтолцоог бэхжүүлнэ. | | | | | | | |
| Зорилт 1.2.Тооцоолол, нотолгоот дүн шинжилгээ, судалгаанд тулгуурласан төлөвлөлтийг хэрэгжүүлж, даатгуулагчийн эрэлт хэрэгцээг хангана. | | | | | | | |
| 1.2.1 | *БГТ 1.2.3* Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, төлбөрийн хяналтад хийгдсэн дүн шинжилгээний мөрөөр | - | Дүн шинжилгээний мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо, хэрэгжилтийн хувь | - | Цахим өгөгдөлд хийсэн дүн шинжилгээнд холбогдох арга хэмжээг авч | I-IV улирал | Б.Ариунболд Б.Чулуунчимэг |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. | | | | хэрэгжүүлсэн байна. | | |
| 1.2.2 | *БГТ 1.2.4*<br>Эрүүл мэндийн даатгалын 2022, 2023 оны үйл ажиллагааны тайлан, статистик мэдээллийн эмхэтгэлийг гэрээт эрүүл мэндийн байгууллага болон олон нийтэд түгээн сурталчилна. | - | Мэдээллээр хангасан ЭМБ, иргэдийн тоо | - | Статистик мэдээллийг олон нийтэд түгээн сурталчилах арга хэмжээг зохион байгуулсан байна. | I-IV улирал | Б.Ариунболд<br>Б.Чулуунчимэг |
| 1.2.3 | "Жагсаалт, төлбөрийн хэмжээ, төлбөрийн арга, журам шинэчлэн батлах тухай" ЭМДҮЗ-ийн тогтоолыг гэрээт ЭМБ-д хүргүүлж хэрэгжилтэд хяналт тавин ажиллана. | - | Шинэчлэн баталсан тогтоолыг хүргүүлсэн ЭМБ-ын тоо, хяналт тавин ажилласан ЭМБ тоо | ЭМДҮЗ-ийн 2023 оны 08 дугаар тогтоолыг мөрдөж байна. | Журмыг хэрэгжүүлсэн байна. | I-IV улирал | Б.Ариунболд<br>Б.Чулуунчимэг |
| 1.2.4 | ЭМДС-аас зардлын төлбөрийг нь хариуцах өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвөөс үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний төлбөрийн хэмжээнд өөрчлөлт оруулах тухай ЭМДҮЗ-ийн тогтоолыг гэрээт ЭМБ-д хүргүүлж хэрэгжилтэд хяналт тавин ажиллана. | - | Журмыг хүргүүлж танилцуулсан ЭМБ-ын тоо, хяналт тавин ажилласан ЭМБ тоо | ЭМДҮЗ 2023 оны 06 дугаар тогтоолыг мөрдөж байна. | Хяналт тавин ажиллаж хэрэгжилтийг тайлагнасан байна. | I-IV улирал | Б.Ариунболд<br>Б.Чулуунчимэг |
| 1.2.5 | Даатгуулагчийг эрт илрүүлэх оношилгоо, шинжилгээнд хамруулсан эрүүл мэндийн байгууллагын тусламж, үйлчилгээний гүйцэтгэлд чанар, төлбөрийн хяналтыг хэрэгжүүлж ажиллана. | - | -Санхүүжүүлсэн мөнгөн дүн<br>-Хамрагдсан даатгуулагчийн тоо | ЭМДҮЗ-ийн 2022 оны 06 дугаар тогтоолыг мөрдөж байна. 2023 онд 3396 иргэн 400,6 сая төгрөгийн | Эрт илрүүлэх оношилгоо, шинжилгээ хийж, гүйцэтгэл ирүүлсэн ЭМБ-уудын гүйцэтгэлд хяналт хийж, | I-IV улирал | Б.Ариунболд<br>Б.Чулуунчимэг |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | санхүүжилт олгосон. | санхүүжилтийг баталгаажуулсан байна. | | |
| 1.2.6 | ЭМД-ын тусламж, үйлчилгээний гүйцэтгэлд хагас жил тутам дүн шинжилгээ хийх, гүйцэтгэлд нөлөөлж буй хүчин зүйлсийг тодорхойлох, хэрэгжүүлэх бодлогын арга хэмжээний санал боловсруулж, Бодлого төлөвлөлтийн газарт хүргүүлнэ. | - | Хийсэн дүн шинжилгээний тоо, Бодлого төлөвлөлтийн газарт хүргүүлсэн саналын тоо | - | Хагас жил тутам дүн шинжилгээ хийж, санал боловсруулан Бодлого төлөвлөлтийн газарт хүргүүлсэн байна. | II, IV улирал | Б.Ариунболд Б.Чулуунчимэг |
| Зорилт 1.4. Салбарын хууль эрх зүйн орчинг боловсронгуй болгоно: | | | | | | | |
| 1.4.1 | *БСТ 2.1.3, БГТ-1.4.3*<br><br>Салбарын хууль тогтоомж, гэрээ, санамж бичиг, эрх зүйн актын төсөлд санал өгнө. | - | Хүргүүлсэн саналын тоо | Эрүүл мэндийн даатгалын тухай, Эрүүл мэндийн тухай, Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн шинэчилсэн найруулгад 4 удаа хүргүүлсэн. | Эрх зүйн баримт бичигт холбогдох саналыг боловсруулж хүргүүлсэн байна. | I-IV улирал | Б.Ариунболд Б.Чулуунчимэг |
| 1.4.2 | Зөрчлийн тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн хэрэгжилтийг хариуцсан нутаг дэвсгэрийн хэмжээнд зохион байгуулж, Прокурорын байгууллагатай хамтран ажиллана. | - | Зөрчлийн хэргийн тоо<br>Санд төвлөрүүлсэн мөнгөн дүн | 2023 оны аймгийн Прокурорын байгууллагатай хамтран гэмт хэрэгт холбогдсон 72 хүний судалгааг гарган өгч 6 хүнийг шүүхийн байгууллагад шилжүүлсэн. | Зөрчил шалган шийдвэрлэх үйл ажиллагааг хууль тогтоомжийн хүрээнд явуулсан байна. | I-IV улирал | Б.Ариунболд Б.Чулуунчимэг |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| **Зорилго 2: Эрүүл мэндийн даатгалын хамралт, орлогыг нэмэгдүүлж, үзүүлэх тусламж, үйлчилгээний тоо хэмжээ, хүрээг өргөтгөнө.** | | | | | | | |
| Зорилт 2.1. Эрүүл мэндийн даатгалын хамралт, орлого, тусламж, үйлчилгээний тоо хэмжээг нэмэгдүүлнэ. | | | | | | | |
| 2.1.1 | *ЭМДТХ-9.1.9, "Алсын хараа 2050" МУУХХБ-2.2.19, БСТ-2.1.1, 2.1.2, МУХТЖҮЧ-2.2.5, МУЗГҮАХ 2.1.7, БГТ 2.1.1*<br><br>Эрүүл мэндийн даатгалын шимтгэлээ өөрөө хариуцан төлөх иргэдийн шимтгэл төлөлтийг нэмэгдүүлэх үйл ажиллагааг зохион байгуулна. | - | Малчдын эрүүл мэндийн даатгалд хамрагдалтын хувь | 2023 оны хамрагдалт 80 хувь | Малчдын эрүүл мэндийн даатгалд хамрагдалтын хувь 2024 онд 50-80 хувь | I-IV улирал | Б.Ариунболд Б.Чулуунчимэг |
| | | | Оюутны эрүүл мэндийн даатгалд хамрагдалтын хувь | 2023 оны хамрагдалт 15.8 хувь | Оюутны эрүүл мэндийн даатгалд хамрагдалтын хувь 2024 онд 100 хувь | | |
| | | | Тодорхой ажил хөдөлмөр эрхлээгүй иргэдийн ЭМДаатгалд хамрагдалтын хувь | 2023 оны хамрагдалт 111 хувь | Тодорхой ажил хөдөлмөр эрхлээгүй иргэдийн ЭМДаатгалд хамрагдалтын хувь 2024 онд 80 хувь | | |
| | | | Байгууллага, аж ахуйн нэгжийн хамрагдалтын хувь | 2023 оны хамрагдалт хувь 106 | -Байгууллага, аж ахуйн нэгжийн хамрагдалтын хувь 2024 онд 100 | | |
| 2.1.2 | Сангийн зарлагын төсвийн гүйцэтгэлд хяналт тавьж тайлан, мэдээг гарган холбогдох нэгжид хүргүүлнэ. | - | Нэгтгэн хүргүүлсэн тайлангийн тоо | 2023 онд сангийн зарлагын төсвийн гүйцэтгэлд хяналт тавих тайланг 4 удаа гарган хүргүүлсэн. | Тайлан, мэдээг хугацаанд нь, үнэн зөв гарган хүргүүлсэн байна. | I-IV улирал | Б.Ариунболд Б.Чулуунчимэг |
| 2.1.3 | *ЭМДТХ-9.1.9, "Алсын хараа 2050" МУУХХБ-2.2.19, БСТ-2.1.1, 2.1.2, МУХТЖҮЧ-2.2.5, МУЗГҮАХ 2.1.7,*<br>Эрүүл мэндийн даатгалын төсвийн сангийн орлогын төлөвлөгөөний биелэлт зардлын | - | Төвлөрүүлсэн мөнгөн дүн | 2023 оны орлогын төлөвлөгөөний биелэлт 77.2 хувьтай байна. | ЭМД-ын орлогын төлөвлөгөөний биелэлтийг 90-ээс доошгүй хувь хэрэгжүүлэн ажилласан байна. | I-IV улирал | Б.Ариунболд Б.Чулуунчимэг |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | гүйцэтгэлийг хангуулж, тайлагнана. | | | | | | |
| Зорилт 2.2. Даатгалын сангийн тогтвортой байдлыг хангаж, эрсдэлээс хамгаална. | | | | | | | |
| 2.2.1 | *БСТ 2.2.1, БГТ-2.2.1*<br><br>Өглөг, авлага үүсгэхгүй ажиллана. Авлага барагдуулах чиглэлээр зохион байгуулалтын арга хэмжээ авна. | , | Өглөг, авлагын тоо хэмжээ, тайлан | 2023 онд 13,0 сая төгрөгний авлагатай, 545,5 сая төгрөгийн өглөгтэй тайланг ЭМДЕГ-т хүргүүлсэн. | Өглөг, авлага барагдуулах чиглэлээр арга хэмжээ авч ажилласан байна | I-IV улирал | Б.Ариунболд Б.Чулуунчимэг |
| **Зорилго 3: Тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулж, худалдан авах үйл ажиллагааг хялбарчилна** | | | | | | | |
| Зорилт 3.1. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгчийн чанарт үндэслэн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ худалдан авч, чанарын хяналтыг сайжруулна. | | | | | | | |
| 3.1.1 | *БСТ 3.1.2, БГТ 3.1.1*<br><br>Лавлагаа шатлалын эрүүл мэндийн байгууллага, өрх, сум тосгоны эрүүл мэндийн төв, эмийн сангуудын 2023 оны гэрээг дүгнэх ажлыг зохион байгуулна. | - | Гэрээ дүгнүүлсэн байгууллагын тоо | 50 гэрээт эрүүл мэндийн байгууллагыг дүгнэсэн. | Гэрээт ЭМБ-уудын гэрээг хагас, бүтэн жилээр хугацаанд нь дүгнэж, холбогдох арга хэмжээний саналыг Худалдан авалт гэрээлэлтийн газарт хүргүүлсэн байна. Гэрээний биелэлтийн хувь 90 хувиас доошгүй. | I-IV улирал | Б.Ариунболд Б.Чулуунчимэг |
| | | | Гэрээний хэрэгжилтийн хувь | Гэрээний хэрэгжилт 85,7 хувь | | I улирал | Б.Ариунболд Б.Чулуунчимэг |
| Зорилт 3.2. Даатгуулагчид үзүүлсэн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанарт холбогдох стандарт, эмнэлзүйн удирдамж, журмын дагуу хяналт тавьж, тусламж, үйлчилгээний чанарыг тасралтгүй сайжруулна | | | | | | | |
| 3.2.1 | *БГТ 3.2.1*<br>Олон улсын эмнэлзүйн удирдамжид суурилсан шалгуурыг үндэслэн гэрээт эрүүл мэндийн байгууллагуудад нэхэмжлэлийн хяналтыг хэрэгжүүлнэ. | ЭМ ДС | Гүйцэтгэл ирүүлсэн ЭМБ-ын тоо, нэхэмжилсэн даатгуулагчийн тоо, мөнгөн дүн, | Нийт 50 ЭМБ-д 23,9 тэрбум төгрөгийн нэхэмжлэлийн гүйцэтгэл хянагдсан. | Нэхэмжлэлийн нарийвчилсан хяналтыг журмын дагуу хэрэгжүүлсэн байна. | I-IV улирал | Б.Ариунболд Б.Чулуунчимэг |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 3.2.2 | *БГТ 3.2.3* Гэрээт эрүүл мэндийн байгууллагад зөвлөн туслах үйлчилгээ үзүүлнэ. | - | Зөвлөн туслах үйлчилгээ үзүүлсэн байгууллагын тоо | 2023 онд 9 ЭМБ-д зөвлөн туслах үйлчилгээ үзүүлсэн. | Эрсдэлийн үнэлгээнд тулгуурлан зөвлөн туслах үйлчилгээг үзүүлсэн байна. | I-IV улирал | Б.Ариунболд Б.Чулуунчимэг |
| 3.2.3 | Гэрээт эрүүл мэндийн байгууллагуудын тусламж, үйлчилгээний нэхэмжлэлд дүн шинжилгээ хийж, шаардлагатай тохиолдолд ЭМД-ын улсын байцаагч (ахлах)-ийн зөвлөмжийг тухай бүр хүргүүлж, биелэлтийг хангуулна. | - | Хүргүүлсэн зөвлөмжийн тоо Зөвлөмжийн хэрэгжилтийн хувь | 2023 онд нийт давхардсан тоогоор 69 эрүүл мэндийн байгууллагад зөвлөмж хүргүүлэн ажилласан. | Тусламж, үйлчилгээний чанар хэрхэн сайжирсан талаарх тайланг холбогдох нэгжид хүргүүлсэн байна. | I-IV улирал | Б.Ариунболд Б.Чулуунчимэг |
| 3.2.4 | *БСТ 3.2.3, БГТ-3.2.2* Нэхэмжлэлийн хяналтын үр дүн болон даатгуулагчдын гомдол, санал үндэслэн эрүүл мэндийн байгууллагуудад газар дээрх хяналт шалгалт хийнэ. | - | Газар дээрх хяналт, шалгалт хийсэн ЭМБ-ын тоо Хяналт, шалгалтын тайлан | 2023 онд гэрээт 6 байгууллагад газар дээрхи хяналт шалгалтыг зохион байгуулсан. | Газар дээрх хяналт, шалгалт хийж тайланг холбогдох нэгжид хүргүүлсэн байна. | I-IV улирал | Б.Ариунболд Б.Чулуунчимэг |
| **Зорилго 4: Эрүүл мэндийн даатгалын үйл ажиллагааг төрийн захиргааны нэгдсэн удирдлага зохион байгуулалтаар хангана.** | | | | | | | |
| Зорилт 4.1. Хүний нөөцийн менежментийг байгууллагын онцлог, хэрэгцээ шаардлагад нийцүүлэн хэрэгжүүлж, суралцагч байгууллага болон хөгжинө. | | | | | | | |
| 4.1.1 | *ЗГҮАХ-2.1.9, БГТ 4.1.3* Ажилтнуудын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр, Сургалтын хөтөлбөрийн хүрээнд хэлтэс, албан хаагчдад чиглэсэн арга хэмжээг орон нутагтай хамтарч хэрэгжүүлнэ. | - | Авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо, тайлан | Ажилтнуудын ажиллах нөхцөлийг хангах үүднээс аймгийн 2023 оны орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 10 сая төгрөгний тавилга тоног төхөөрөмж, ЭМДЕГ-н урсгал засвараар ажлын | Арга хэмжээ авч хэрэгжүүлсэн байна. | I-IV улирал | Б.Ариунболд Б.Чулуунчимэг |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | байрыг үасварласан. | | | |
| 4.1.2 | *БГТ 4.1.4* Ерөнхий газраас баталсан Сургалтын хөтөлбөрийн хүрээнд зохион байгуулах сургалтад тогтмол хамрагдана. | - | Хамрагдсан сургалтын тоо | ЭМДЕГ-аас зохион байгуулсан сургалтад тогтмол хамрагдсан. | Ерөнхий газраас зохион байгуулах нийт сургалтад тогтмол хамрагдаж мэдээлэл авсан байна. | I-IV улирал | Б.Ариунболд Б.Чулуунчимэг |
| 4.1.3 | Салбарын хууль тогтоомж, тогтоол шийдвэрийг сурталчлах, даатгалын орлого хамралтыг нэмэгдүүлэхэд чиглэсэн нээлттэй өдөрлөг,сургалт, сурталчилгааны бусад арга хэмжээг зохион байгуулна. | - | Зохион байгуулсан арга хэмжээ, сургалтын тоо | Зохион байгуулсан арга хэмжээ-2, сургалтын тоо-3 | Сургалт, сурталчилгааны арга хэмжээг зохион байгуулж, тайлагнасан байна. | I-IV улирал | Б.Ариунболд Б.Чулуунчимэг |
| 4.1.4 | Байгууллагын үйл ажиллагааны болон мэдээллийн ил тод байдлыг хангуулах ажлыг нутаг дэвсгэрийн хэмжээнд зохион байгуулж, иргэн-даатгуулагчид бодит мэдээ, мэдээлэл хүргэнэ. | - | Иргэд, даатгуулагчдад хүргэсэн мэдээлэл, хандалтын тоо | Иргэд, даатгуулагчийн тоо- 2254 Хүргүүлсэн мэдээллийн тоо-12 | 1000-аас доошгүй иргэн даатгуулагчдад мэдээлэл хүргэсэн байна. | I-IV улирал | Б.Ариунболд Б.Чулуунчимэг |
| 4.1.5 | *БГТ 4.1.8* Даатгуулагч-иргэд, гэрээт байгууллага, ажилтнуудаас сэтгэл ханамжийн судалгаа авах ажлыг зохион байгуулж, түүний мөрөөр зохих арга хэмжээг авч, нэгдсэн тайланг ерөнхий газарт хүргүүлнэ. | - | Судалгаанд хамрагдсан иргэдийн тоо | 352 иргэн судалгаанд хамрагдсан | Сэтгэл ханамжийн судалгаа авч, нэгдсэн тайланг ерөнхий газарт хүргүүлсэн байна. | II , IV улирал | Б.Ариунболд Б.Чулуунчимэг |
| 4.1.6 | Иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн санал, хүсэлт, өргөдөл, гомдлыг хуулийн хугацаанд, үнэн зөв шийдвэрлэх ажлыг зохион байгуулж, шийдвэрлэлтэд хяналт тавьж тайлагнана. | - | Албан бичиг, өргөдөл, гомдлын тоо, шийдвэрлэлтийн хувь | Албан бичиг, өргөдөл, гомдлын тоо 104, шийдвэрлэлт 100 хувь. | Албан бичиг, өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн мэдээг хагас, бүтэн жилээр нэгтгэн тайланг ерөнхий | I-IV улирал | Б.Ариунболд Б.Чулуунчимэг |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | газарт хүргүүлсэн байна. | | |
| 4.1.7 | Нэгжийн албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөөг баталж, хэрэгжилт, цаг бүртгэлд хяналт тавих, ажил үүргийг тэнцвэртэй, оновчтой хуваарилах, зөвлөн туслах, чиглүүлэх, өдөр тутмын удирдлагаар хангах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ. | | Албан хаагчийн ажлын гүйцэтгэлийн төлөвлөгөөний | Хэлтсийн мэргэжилтэний гүйцэтгэлийн төлөвлөгөөг байгуулж гүйцэтгэлийг хагас болон бүтэн жилээр дүгнэж ЭМДЕГ-т хүргүүлэн ажилласан. | Гүйцэтгэлийн төлөвлөгөө байгуулж, ажлын гүйцэтгэл, үр дүнг хагас, бүтэн жилээр үнэлж, дүгнэсэн байна. | I-IV улирал | Б.Ариунболд |
| 4.1.8 | Албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааг стандарт, зааврын дагуу явуулж, архивын нэгж бүрдүүлж, ЭМДЕГ-ын архивт хугацаанд хүлээлгэж өгнө. | - | Бүрдүүлсэн архивын нэгжийн тоо | 2023 онд 2021, 2022 оны нийт 105 хадгаламжийн нэгж хүргүүлсэн | Албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааг стандарт, зааврын дагуу явуулж, архивын нэгж бүрдүүлсэн байна | I-улирал | Б.Ариунболд<br>Б.Чулуунчимэг |
| 4.1.9 | Даргын зөвлөлийн болон шуурхай хуралдаан, цаг үеийн шинжтэй удирдлагаас өгөгдсөн үүрэг даалгаврын хэрэгжилтийг хангаж, биелэлтийг хугацаанд нь үнэн зөвөөр тайлагнана. | - | Хугацаанд нь тайлагнасан үүрэг даалгаврын тоо, хэрэгжилтийн хувь. | Үүрэг даалгаврын хэрэгжилт 2023 онд 80 хувь | Цаг үеийн шинжтэй удирдлагаас өгөгдсөн үүрэг даалгаврын хэрэгжилтийг хангаж, биелэлтийг хугацаанд нь үнэн зөвөөр тайлагнасан байна. | I-IV улирал | Б.Ариунболд<br>Б.Чулуунчимэг |

-ooOoo-

**БУЛГАН АЙМАГ ДАХЬ ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН ХЭЛТСИЙН**
**2024 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ 4-Р УЛИРЛЫН БИЕЛЭЛТ**

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/ | Гүйцэтгэ -лийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Эхний хагас жил | Сүүлийн хагас жил | | |
| **Зорилго 1**. Даатгуулагчийн эрэлт хэрэгцээ, шаардлагад нийцсэн цахим тогтолцоог бэхжүүлнэ. | | | | | | | | |
| **Зорилт 1.2**.Тооцоолол, нотолгоот дүн шинжилгээ, судалгаанд тулгуурласан төлөвлөлтийг хэрэгжүүлж, даатгуулагчийн эрэлт хэрэгцээг хангана. | | | | | | | | |
| 1.2.1 | *БГТ 1.2.3* Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, төлбөрийн хяналтад хийгдсэн дүн шинжилгээний мөрөөр холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. | - | Дүн шинжилгээний мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо, хэрэгжилтийн хувь | | Цахим өгөгдөлд хийсэн дүн шинжилгээнд холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлсэн байна. | Цахим өгөгдөлд хийсэн дүн шинжилгээнд холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлсэн байна. | Тус хэлтэс эхний 11 сарын байдлаар давхардсан тоогоор Лавлагаа шатлалын 216 эмнэлгийн 17,192, анхан шатны 57 эмнэлгийн 537 түүвэрт хяналт хийсэн. Хяналтаар гарсан алдаа дутагдлын талаар 89 эрүүл мэндийн байгууллагад улсын ахлах байцаагчийн зөвлөмж хүргүүлэн ажилласан. | 80 |
| 1.2.2 | *БГТ 1.2.4* Эрүүл мэндийн даатгалын 2022, 2023 оны үйл | | Мэдээллэл хангасан ЭМБ, иргэдийн тоо | | Статистик мэдээллийг олон нийтэд түгээн сурталчилах арга хэмжээг | Статистик мэдээллийг олон нийтэд түгээн сурталчилах арга хэмжээг | Гэрээт 49 байгууллагын 2020 оноос хойшхи санхүүжилтийн судалгааг тусламж үйлчилгээ тус бүрээр гарган бэлдэж аймгийн | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | ажиллагааны тайлан, статистик мэдээллийн эмхэтгэлийг гэрээт эрүүл мэндийн байгууллага болон олон нийтэд түгээн сурталчилна. | | | | зохион байгуулсан байна | зохион байгуулсан байна | Засаг даргын мөрийн хөтөлбөрийн тайланд тусгуулсан. ЭМДЕГ-аас Эрүүл мэндийн даатгалын сангийн 2022, 2023 оны үйл ажиллагааны тайлан, статистик мэдээллийн эмхэтгэлийг гарган ирсэн үед гэрээт эрүүл мэндийн байгууллага болон олон нийтэд түгээн сурталчилан түгээх ажлыг зохион байгуулна. Харин ЭМДЕГ-аас энэ онд хэвлэгдэн ирсэн 12 нэр төрлийн брошур, хэвлэмэл хуудсыг гэрээт 49 гэрээт эрүүл мэндийн байгууллага болон аймаг сумын төвд үйл ажиллагаа явуулдаг зах, худалдааны төв, хүнс болон барилгын дэлгүүрүүдээр тараан байрлуулж иргэдэд мэдээлэл өгч ажиллалаа. Давхардсан тоогоор аймгийн хэмжээнд нийт 32,752 иргэнд мэдээлэл өгсөн байна. | 80 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1.2.3 | "Жагсаалт, төлбөрийн хэмжээ, төлбөрийн арга, журам шинэчлэн батлах тухай" ЭМДҮЗ-ийн тогтоолыг гэрээт ЭМБ-д хүргүүлж хэрэгжилтэд хяналт тавин ажиллана. | | Шинэчлэн баталсан тогтоолыг хүргүүлсэн ЭМБ-ын тоо, хяналт тавин ажилласан ЭМБ тоо | ЭМДҮЗ-ийн 2023 оны 08 дугаар тогтоолыг мөрдөж байна. | Журмыг хэрэгжүүлсэн байна. Гэрээт 50 эрүүл мэндийн байгууллагад хяналт тавин ажиллана. | Журмыг хэрэгжүүлсэн байна. Гэрээт 50 эрүүл мэндийн байгууллагад хяналт тавин ажиллана. | ЭМДҮЗ-ийн шинэчлэгдэн гарсан тогтоолын талаархи сургалтыг ЭМДЕГ-аас 6 удаа цахимаар зохион байгуулах үед гэрээт 50 эрүүл мэндийн байгууллага болон холбоодуудын төлөөлөл, ЭМГ-н холбогдох мэргэжилтнүүд, хэлтсийн 3 ажилтан тус тус хамрагдлаа. Мөн ЭМДҮЗ-ийн тогтоол хэрэгжсэн өдрөөс эхлэн гэрээт ЭМБ-дад хэрэгжүүлэн хэрэгжилтэнд хяналт тавин ажиллаж байна. | 90 |
| 1.2.4 | ЭМДС-аас зардлын төлбөрийг нь хариуцах өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвөөс үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний төлбөрийн хэмжээнд өөрчлөлт оруулах тухай ЭМДҮЗ-ийн тогтоолыг | | Журмыг хүргүүлж танилцуулсан ЭМБ-ын тоо, хяналт тавин ажилласан ЭМБ тоо | ЭМДҮЗ 2023 оны 06 дугаар тогтоолыг мөрдөж байна. | Журмыг хэрэгжүүлсэн байна. Гэрээт 50 эрүүл мэндийн байгууллагад хяналт тавин ажиллана. | Журмыг хэрэгжүүлсэн байна. Гэрээт 50 эрүүл мэндийн байгууллагад хяналт тавин ажиллана. | ЭМДҮЗ-ийн шинэчлэгдэн гарсан тогтоолын талаархи сургалтыг ЭМДЕГ-аас 3 удаа цахимаар зохион байгуулах үед гэрээт 16 эрүүл мэндийн байгууллага болон холбоодуудын төлөөлөл, ЭМГ-н холбогдох мэргэжилтнүүд, хэлтсийн 3 ажилтан тус тус хамрагдлаа. Мөн тогтоолын өөрчлөлттэй холбогдуулан тус хэлтсээс сургалтыг 18 байгууллагын 34 эмч | 80 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | гэрээт ЭМБ-д хүргүүлж хэрэгжилтэд хяналт тавин ажиллана. | | | | | | сувилагч нарт хийж ажиллалаа. Мөн ЭМДҮЗ-ийн тогтоол хэрэгжсэн өдрөөс эхлэн гэрээт ЭМБ-дад хэрэгжүүлэн хэрэгжилтэнд хяналт тавин ажиллаж байна. | |
| 1.2.5 | Даатгуулагчийг эрт илрүүлэх оношилгоо, шинжилгээнд хамруулсан эрүүл мэндийн байгууллагын тусламж, үйлчилгээний гүйцэтгэлд чанар, төлбөрийн хяналтыг хэрэгжүүлж ажиллана. | | - Санхүүжүүлсэн мөнгөн дүн - Хамрагдсан даатгуулагчийн тоо | ЭМДҮЗ-ийн 2022 оны 06 дугаар тогтоолыг мөрдөж байна. 2023 онд 3396 иргэн 400,6 сая төгрөгийн санхүүжилт олгосон. | Эрт илрүүлэх оношилгоо, шинжилгээ хийж, гүйцэтгэл ирүүлсэн ЭМБ-уудын гүйцэтгэлд хяналт хийж, санхүүжилтийг баталгаажуулсан байна. | Эрт илрүүлэх оношилгоо, шинжилгээ хийж, гүйцэтгэл ирүүлсэн ЭМБ-уудын гүйцэтгэлд хяналт хийж, санхүүжилтийг баталгаажуулсан байна. | Аймгийн Нэгдсэн эмнэлэг даатгуулагчийг эрт илрүүлэх оношилгоо, шинжилгээнд 430 иргэн хамруулан 407 иргэний 41.667.000 төгрөг нэхэмжилсэн. Үүнээс 23 иргэний 2.380.000 төгрөгийг хасалт хийгдэж 407 иргэний 39.287.000 төгрөг олгосон. | 90 |
| 1.2.6 | ЭМД-ын тусламж, үйлчилгээний гүйцэтгэлд хагас жил тутам дүн шинжилгээ хийх, гүйцэтгэлд нөлөөлж буй хүчин зүйлсийг тодорхойлох, хэрэгжүүлэх бодлогын арга | | Хийсэн дүн шинжилгээний тоо, Бодлого төлөвлөлтийн газарт хүргүүлсэн саналын тоо | - | Хагас жил тутам дүн шинжилгээ хийж, санал боловсруулан Бодлого төлөвлөлтийн газарт хүргүүлсэн байна. | Хагас жил тутам дүн шинжилгээ хийж, санал боловсруулан Бодлого төлөвлөлтийн газарт хүргүүлсэн байна. | ЭМДсангийн тусламж үйлчилгээний эхний улирлын санхүүжилтийн судалгааг тусламж үйлчилгээ тус бүрээр гарган санхүүжилт нь 20-40 хувь өссөн гэрээт эрүүл мэндийн байгууллагын судалгааг гаргасан. Үүнийг үндэслэн Бодлого төлөвлөлтийн газарт уламжилж тухайн байгууллагад газар дээрхий хяналт хийхээр | 80 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хэмжээний санал боловсруулж, Бодлого төлөвлөлтийн газарт хүргүүлнэ. | | | | | төлөвлөн ажилласны хүрээнд аймгийн төвд үйл ажиллагаа явуулдаг 7 эмийн сан, 2 өрхийн ЭМТ, 3 сумын ЭМТ-д газар дээрхий хяналт шалгалтыг хийж ажиллалаа. | |
| **Зорилт 1.4.** "Салбарын хууль эрх зүйн орчинг боловсронгуй болгоно" зорилтын хүрээнд | | | | | | | |
| 1.4.1 | Салбарын хууль тогтоомж, гэрээ, санамж бичиг, эрх зүйн актын төсөлд санал өгнө. | - | Хүргүүлсэн саналын тоо | Эрүүл мэндийн даатгалын тухай, Эрүүл мэндийн тухай, Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн шинэчилсэн найруулгад 4 удаа хүргүүлсэн. | Эрх зүйн баримт бичигт холбогдох саналыг боловсруулж хүргүүлсэн байна. | Эрх зүйн баримт бичигт холбогдох саналыг боловсруулж хүргүүлсэн байна. | Энэ онд өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвөөс үзүүлэх зарим тусламж, үйлчилгээ болон урьдчилан сэргийлэх үзлэг, эрт илрүүлэх оношилгоо шинжилгээний нэхэмжлэлийн хяналтын шинэчлэн боловсруулсан шалгуурын төсөлд 16 сумын эрүүл мэндийн төв, 2 өрхийн эрүүл мэндийн төвөөс 3 удаа санал авч нэгтгэн хүргүүллээ. | 90 |
| 1.4.2 | Зөрчлийн тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн хэрэгжилтийг хариуцсан нутаг дэвсгэрийн хэмжээнд зохион байгуулж, Прокурорын | - | Зөрчлийн хэргийн тоо Санд төвлөрүүлсэн мөнгөн дүн | 2023 оны аймгийн Прокурорын байгууллагатай хамтран гэмт хэрэгт холбогдсон 72 хүний судалгаа гарган өгч 6 | Зөрчил шалган шийдвэрлэх үйл ажиллагааг хууль тогтоомжийн хүрээнд явуулсан байна. | Зөрчил шалган шийдвэрлэх үйл ажиллагааг хууль тогтоомжийн хүрээнд явуулсан байна. | Энэ онд аймгийн Цагдаагийн газар, прокурорын газарт гэмт хэрэгт холбогдсон 171 иргэний эрүүл мэндийн даатгалын сангаас зарцуулсан санхүүжилтийн судалгаа гарган хүргүүлж, шуухийн | 90 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | байгууллагатай хамтран ажиллана. | | | хүнийг шүүхийн байгууллагад шилжүүлсэн. | | | байгууллагад 47 иргэний хэргийг шилжүүлэн, 47 иргэний хэрэгт нэхэмжлэгчээр оролцон 41 иргэний 37,854,652 төгрөгийг Эрүүл мэндийн даатгалын санд төвлөрүүлэн ажиллалаа. | |
| **Зорилго 2:** Эрүүл мэндийн даатгалын хамралт, орлогыг нэмэгдүүлж, үзүүлэх тусламж, үйлчилгээний тоо хэмжээ, хүрээг өргөтгөнө. | | | | | | | | |
| **Зорилго 2.1.** “Эрүүл мэндийн даатгалын хамралт, орлого, тусламж, үйлчилгээний тоо хэмжээ нэмэгдүүлнэ” зорилтын хүрээнд: | | | | | | | | |
| 2.1.1 | *ЭМДТХ-9.1.9, “Алсын хараа 2050” МУУХХБ-2.2.19, БСТ-2.1.1, 2.1.2, МУХТЖҮЧ-2.2.5, МУЗГҮАХ 2.1.7, БГТ-2.1.1* Эрүүл мэндийн даатгалын төсвийн сангийн орлогын төлөвлөгөөний биелэлт зардлын гүйцэтгэлийг хангуулж, тайлагнана. | - | Малчдын эрүүл мэндийн даатгалд хамрагдалтын хувь | 2023 оны хамрагдалт 80 хувь | Малчдын эрүүл мэндийн даатгалд хамрагдалтын хувь 2024 онд 50-80 хувь | Малчдын эрүүл мэндийн даатгалд хамрагдалтын хувь 2024 онд 50-80 хувь | ЭМДЕГ-ын даргын тушаалаар энэ онд 7036 малчин хамруулахаас 2024.11.25-ны байдлаар 3560 малчин хамруулж 352,6 сая төгрөг төвлөрүүлсэн. Хамрагдалт-50,6 хувь | 86 |
| | | | Оюутны эрүүл мэндийн даатгалд хамрагдалтын хувь | 2023 оны хамрагдалт 15.8 хувь | Оюутны эрүүл мэндийн даатгалд хамрагдалтын хувь 2024 онд 100 хувь | Оюутны эрүүл мэндийн даатгалд хамрагдалтын хувь 2024 онд 100 хувь | ЭМДЕГ-ын даргын тушаалаар энэ онд 11 оюутан хамруулахаас 2024.11.25-ны байдлаар 1108 оюутан хамруулж 90,6 сая төгрөг төвлөрүүлсэн. Хамрагдалт- | |
| | | | Тодорхой ажил хөдөлмөр эрхлээгүй иргэдийн ЭМДаатгалд хамрагдалтын хувь | 2023 оны хамрагдалт 111 хувь | Тодорхой ажил хөдөлмөр эрхлээгүй иргэдийн ЭМДаатгалд хамрагдалтын хувь 2024 онд 80 хувь | Тодорхой ажил хөдөлмөр эрхлээгүй иргэдийн ЭМДаатгалд хамрагдалтын хувь 2024 онд 80 хувь | ЭМДЕГ-ын даргын тушаалаар энэ онд 1815 хувираа хөдөлмөр эрхлэгч хамруулахаас 2024.05.14-ны байдлаар 2439 хувираа хөдөлмөр эрхлэгч хамруулж 183,9 сая төгрөг төвлөрүүлсэн. Хамрагдалт-134,3,3 хувь | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Байгууллага, аж ахуйн нэгжийн хамрагдалтын хувь | 2023 оны хамрагдалт хувь 106 | -Байгууллага, аж ахуйн нэгжийн хамрагдалтын хувь 2024 онд 100 | -Байгууллага, аж ахуйн нэгжийн хамрагдалтын хувь 2024 онд 100 | Аймгийн хэмжээнд 2000 орчим Байгууллага, аж ахуйн нэгж байгууллагын 6000 орчим иргэн хамрагдахаас өнөөдрийн байдлаар 5173 иргэн хамрагдаж байна. Хамрагдалт-86,2 хувь /Тус мэдээллийг аймгийн Нийгмийн даатгалын газраас авсан болно./ | |
| 2.1.2 | Сангийн зарлагын төсвийн гүйцэтгэлд хяналт тавьж тайлан, мэдээг гарган холбогдох нэгжид хүргүүлнэ. | - | Нэгтгэн хүргүүлсэн тайлангийн тоо | 2023 онд сангийн зарлагын төсвийн гүйцэтгэлд хяналт тавих тайланг 4 удаа гарган хүргүүлсэн. | Тайлан, мэдээг хугацаанд нь, үнэн зөв гарган хүргүүлсэн байна. | Тайлан, мэдээг хугацаанд нь, үнэн зөв гарган хүргүүлсэн байна. | 2024 оны 1-3 дугаар санхүүгийн тайланг гарган нэгтгэж Санхүү бүртгэлийн хэлтэст хүргүүлэн аймгийн удирдлагуудад танилцуулан ажиллалаа. | 90 |
| 2.1.3 | *ЭМДТХ-9.1.9, "Алсын хараа 2050" МУУХХБ-2.2.19, БСТ-2.1.1, 2.1.2, МУХТЖҮЧ-2.2.5, МУЗГҮАХ 2.1.7,* Эрүүл мэндийн даатгалын төсвийн сангийн орлогын төлөвлөгөөний биелэлт зардлын гүйцэтгэлийг хангуулж, тайлагнана. | - | Төвлөрүүлсэн мөнгөн дүн | 2023 оны орлогын төлөвлөгөөний биелэлт 77.2 хувьтай байна. | ЭМД-ын орлогын төлөвлөгөөний биелэлтийг 90-ээс доошгүй хувь хэрэгжүүлэн ажилласан байна. | ЭМД-ын орлогын төлөвлөгөөний биелэлтийг 90-ээс доошгүй хувь хэрэгжүүлэн ажилласан байна. | ЭМДЕГ-ын даргын тушаалаар энэ онд 7,3 тэрбум төгрөг төвлөрүүлэхээс 2024.11.25-ны байдлаар 5,9 тэрбум төгрөг төвлөрүүлж орлогын төлөвлөгөө 81 хувиар биеллээ. Мөн гэрээт байгууллагын нэхэмжлэлийн хяналтыг хуваарилагдсан байцаагч нар хяналт хийн эхний 8 сарын санхүүжилтийг 100 хувь олгон ажиллаж байна. Эрүүл мэндийн даатгалын сангийн төсөв хүндэрсэнтэй холбогдуулан 2024 оны 09 болон 10 дугаар сарын | 81 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | санхзүүжилтийг олгож чадаагүй байна. | |
| **Зорилго 2.2** "Даатгалын сангийн тогтвортой байдлыг хангаж, эрсдэлээс хамгаална" зорилтын хүрээнд | | | | | | | | |
| 2.2.1 | *БСТ 2.2.1, БГТ-2.2.1*<br><br>Өглөг, авлага үүсгэхгүй ажиллана. Авлага барагдуулах чиглэлээр зохион байгуулалтын арга хэмжээ авна. | ЭМДС | Өглөг, авлагын тоо хэмжээ, тайлан | 2023 онд 13,0 сая төгрөгний авлагатай 545,5 сая төгрөгийн өглөгтэй тайланг ЭМДЕГ-т хүргүүлсэн. | Өглөг, авлага барагдуулах чигэлээр арга хэмжээ авч ажилласан байна | Өглөг, авлага барагдуулах чигэлээр арга хэмжээ авч ажилласан байна | 2024 оны эхний 11 сарын байдлаар тус хэлтэс 2022 онд үүссэн Сожид ХХК-ийн авлагыг барагдуулах ажлыг хийн ажиллаж байна. 2024 оны 03 дугаар сард Сожид ХХК-д авлагыг барагдуулах талаар албан бичиг хүргүүлж 04, 05 дугаар сард тус компаний захиралтай утсаар холбогдон авлагыг барагдуулах талаар үүрэг даалгавар өгсөн. Тус компаниас 05 дугаар сард 1,0 сая төгрөгийг төлж барагдуулсан. Харин ЭМДС төсөв хүндэрснээс шалтгаалын энэ оны 9 болон 10 дугаар сарын гэрээм байгууллагын санхүүжилт 3,2 тэрбум төгрөгийн өртэй байна. | 80 |
| **Зорилго 3: Тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулж, худалдан авах үйл ажиллагааг хялбарчилна** | | | | | | | | |
| **Зорилт 3.1.** Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгчийн чанарт үндэслэн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ худалдан авч, чанарын хяналтыг сайжруулна. | | | | | | | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 3.1.1 | *БСТ 3.1.2, БГТ 3.1.1*<br><br>Лавлагаа шатлалын эрүүл мэндийн байгууллага, өрх, сум тосгоны эрүүл мэндийн төв, эмийн сангуудын 2023 оны гэрээг дүгнэх ажлыг зохион байгуулна. | - | Гэрээ дүгнүүлсэн байгууллагын тоо | 50 гэрээт эрүүл мэндийн байгууллагыг дүгнэсэн. | Гэрээт ЭМБ-уудын гэрээг хагас, бүтэн жилээр хугацаанд нь дүгнэж, холбогдох арга хэмжээний саналыг Худалдан авалт гэрээлэлтийн газарт хүргүүлсэн байна. Гэрээний биелэлтийн хувь 90 хувиас доошгүй. | Гэрээт ЭМБ-уудын гэрээг хагас, бүтэн жилээр хугацаанд нь дүгнэж, холбогдох арга хэмжээний саналыг Худалдан авалт гэрээлэлтийн газарт хүргүүлсэн байна. Гэрээний биелэлтийн хувь 90 хувиас доошгүй. | Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын даргын тушаалаар гэрээт 50 байгууллагатай 2023 онд хамтран ажиллах гэрээг дүгнэн тайлан болон холбогдох судалгааг гарган ХАГГ-т хүргүүлсэн. Гэрээ дүгнэхэд 7 эмийн сангийн гэрээг түр түдгэлзүүлэн улсын байцаагчийн зөвлөмж хүргүүлэн ажилласан. Мөн Бугат сумын ЭМТ гэрээний биелэлт хангалтгүй байсан тул ЭМДЕГ-аас улсын байцаагчийн зөвлөмж хүргүүлэн биелэлтийг гаргуулан ажиллаж байна. | 88 |
| | | | Гэрээний хэрэгжилтийн хувь | Гэрээний хэрэгжилт 85,7 хувь | | | Гэрээт 50 байгууллагын гэрээний хэрэгжилт 88,2 хувьтай дүгнэгдсэн. | |
| **Зорилт 3.2** "Даатгуулагчид үзүүлсэн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанарт холбогдох стандарт, эмнэлзүйн удирдамж, журмын дагуу хяналт тавьж, тусламж, үйлчилгээний чанарыг тасралтгүй сайжруулна" зорилтын хүрээнд: | | | | | | | | |
| 3.2.1 | Олон улсын эмнэлзүйн удирдамжид суурилсан шалгуурыг үндэслэн гэрээт эрүүл мэндийн байгууллагуудад нэхэмжлэлийн хяналтыг хэрэгжүүлнэ. | ЭМДС | Гүйцэтгэл ирүүлсэн ЭМБ-ын тоо, нэхэмжилсэн даатгуулагчийн тоо, мөнгөн дүн, | Нийт 50 ЭМБ-д 23,9 тэрбум төгрөгийн нэхэмжлэлийн гүйцэтгэл хянагдсан. | Нэхэмжлэлийн нарийвчилсан хяналтыг журмын дагуу хэрэгжүүлсэн байна. | Нэхэмжлэлийн нарийвчилсан хяналтыг журмын дагуу хэрэгжүүлсэн байна. | **Нэгдсэн эмнэлэг-1** нэхэмжилсэн 10.639.285.390 хасагдал 434.434.065 олгосон 10.204.842.325 төгрөг **Сувилал-2** – нэхэмжилсэн 898.730.000 хасагдал 6.578.000 олгосон 892.152.000 төгрөг **Өрх, сум, тосгоны ЭМТ-18** Нэхэмжилсэн 5.298.633.331 хасагдал 261.047.87 | 80 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | олгосон 5.037.586.244 төгрөг<br>**Төр хариуцах эм** 725 даатгуулагчид 40.745.345.21 төгрөг олгосон.<br>**Эрт илрүүлэг**<br>Нэхэмжилсэн 41.667.000 хасагдал 2.380.000 олгосон 39.287.000<br>**Эмийн сан-29**<br>Нэхэмжилсэн 2.522.215.281 хасагдал 8.655.737 олгосон 2.513.559.544 | |
| 3.2.2 | *БГТ 3.2.3*<br>Гэрээт эрүүл мэндийн байгууллагад зөвлөн туслах үйлчилгээ үзүүлнэ. | | Зөвлөн туслах үйлчилгээ үзүүлсэн байгууллагын тоо | 2023 онд 9 ЭМБ-д зөвлөн туслах үйлчилгээ үзүүлсэн. | Эрсдэлийн үнэлгээнд тулгуурлан зөвлөн туслах үйлчилгээг үзүүлсэн байна. | Эрсдэлийн үнэлгээнд тулгуурлан зөвлөн туслах үйлчилгээг үзүүлсэн байна. | 2023 оны хамтран ажиллах гэрээ дүгнэх ажлын хүрээнд 7 эмийн сангийн гэрээ дүгнэлт хангалтгүй байсан учир тус эмийн сангуудад зөвлөн туслах ажлаар ажилласан. Мөн хэлтсээс 2024 онд газар дээрхи хяналт болон зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэх байгууллагуудын төлөвлөгөө гарган ажиллаж байна. Энэ онд Орхон, Бугат, Баяннуур, Дашинчилэн сумын ЭМТ-д зөвлөн туслахаар ажилласан. Энэ үеэр эмнэлгийн эмч сувтлагчдад мэдээлэл өгч, бүртгэл хөтлөлт, программ дээрхи бүртгэл, гарч байгаа алдааг Мэдээлэл технологийн хэлтэст уламжлан засварлуулсан. | 80 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 3.2.3 | Гэрээт эрүүл мэндийн байгууллагуудын тусламж, үйлчилгээний нэхэмжлэлд дүн шинжилгээ хийж, шаардлагатай тохиолдолд ЭМД-ын улсын байцаагч (ахлах)-ийн зөвлөмжийг тухай бүр хүргүүлж, биелэлтийг хангуулна. | | Хүргүүлсэн зөвлөмжийн тоо Зөвлөмжийн хэрэгжилтийн хувь | 2023 онд нийт давхардсан тоогоор 69 эрүүл мэндийн байгууллагад зөвлөмж хүргүүлэн ажилласан. | Тусламж, үйлчилгээний чанар хэрхэн сайжирсан талаарх тайланг холбогдох нэгжид хүргүүлсэн байна. | Тусламж, үйлчилгээний чанар хэрхэн сайжирсан талаарх тайланг холбогдох нэгжид хүргүүлсэн байна. | Гэрээт эрүүл мэндийн байгууллагуудад сард 1-2 удаа тусламж үйлчилгээний нэхэмжлэлд хяналт хийн нэхэмжлэлийн хяналтаар хасагдсан түүврүүдийг шинжилгээ хийн гэрээт эрүүл мэндийн байгууллагуудад зөвлөмж хүргүүлэн биелэлтэд хяналт тавин ажиллаж байна. Энэ онд зөвлөмж 89 удаа, албан шаардлага 7 удаа гэрээт байгууллагуудад хүргүүлэн ажилласан. | 70 |
| 3.2.4 | *БСТ 3.2.3, БГТ-3.2.2* Нэхэмжлэлийн хяналтын үр дүн болон даатгуулагчдын гомдол, саналд үндэслэн эрүүл мэндийн байгууллагуудад газар дээрх хяналт шалгалт хийнэ. | | Газар дээрх хяналт, шалгалт хийсэн ЭМБ-ын тоо Хяналт, шалгалтын тайлан | 2023 онд гэрээт 6 байгууллагад газар дээрхи хяналт шалгалтыг зохион байгуулсан. | Газар дээрх хяналт, шалгалт хийж тайланг холбогдох нэгжид хүргүүлсэн байна. | Газар дээрх хяналт, шалгалт хийж тайланг холбогдох нэгжид хүргүүлсэн байна. | Нэхэмжлэлийн хяналтын үр дүн болон гэрээт байгууллагаар үйлчлүүлсэн иргэдээс 1 иргэн гомдол гаргаж гомдлын дагуу Нэгдсэн эмнэлэгт газар дээрхи хяналт шалгалт хийж тухайн иргэнд хариуг хүргүүлэн ажилласан. | 80 |
| **Зорилго 4: Эрүүл мэндийн даатгалын үйл ажиллагааг төрийн захиргааны нэгдсэн удирдлага зохион байгуулалтаар хангана.** | | | | | | | | |
| **Зорилт 4.1.** Хүний нөөцийн менежментийг байгууллагын онцлог, хэрэгцээ шаардлагад нийцүүлэн хэрэгжүүлж, суралцагч байгууллага болон хөгжинө. | | | | | | | | |
| 4.1.1 | *ЗГҮАХ-2.1.9, БГТ 4.1.3* | | Авч хэрэгжүүлсэн | Ажилтнуудын ажиллах | Арга хэмжээ авч хэрэгжүүлсэн | Арга хэмжээ авч | Ажилтнуудын ажиллах нөхцөл, нигмийн баталгаар | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Ажилтнуудын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр, Сургалтын хөтөлбөрийн хүрээнд хэлтэс, албан хаагчдад чиглэсэн арга хэмжээг орон нутагтай хамтарч хэрэгжүүлнэ. | | арга хэмжээний тоо, тайлан | нөхцөлийг хангах үүднээс аймгийн 2023 оны орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 10 сая төгрөгний тавилга тоног төхөөрөмж, ЭМДЕГ-н урсгал засвараар ажлын байрыг үасварласан. | байна. | хэрэгжүүлсэн байна. | хангах хөтөлбөрийн хүрээнд 2024 оны аймгийн орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 8,0 сая төгрөгний 2 компьютер, 1 дэлгэцийг хүлээн авлаа. Мөн хамт байрладаг Шүүхийн шинжилгээний байгууллагатай хамтран 00-н өрөөг засварлан, "энэ жилдээ эрүүл жиндээ "аяны хүрээнд ажилчдын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх зорилгоор байгууллагын үүдний хэсэгт ширээний теннисийн ширээ, дартсыг байрлуулан ажиллаж байна. | 100 |
| 4.1.2 | *БГТ 4.1.4* Ерөнхий газраас баталсан Сургалтын хөтөлбөрийн хүрээнд зохион байгуулах сургалтад тогтмол хамрагдана. | | Хамрагдсан сургалтын тоо | ЭМДЕГ-аас зохион байгуулсан сургалтад тогтмол хамрагдсан. | Ерөнхий газраас зохион байгуулах нийт сургалтад тогтмол хамрагдаж мэдээлэл авсан байна. | Ерөнхий газраас зохион байгуулах нийт сургалтад тогтмол хамрагдаж мэдээлэл авсан байна. | Ерөнхий газраас болон аймгаас зохион байгуулсан сургалтад хэлтсийн ажилчид хамрагдаж байна. Үүнд:<br>- ТАЗ-с зохион байгуулагддаг сургалт<br>- ЭМДЕГ-аас ЭМДҮЗ-ийн тогтоолын өөрчлөлтийн талаархи сургалтад цахимаар 6 удаа<br>- Аймгийн Засаг даргын Тамгын газрын архивын тасгаас зохион байгуулсан сургалт<br>- Аймгийн Засаг | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | даргын тамгын газраас зохион байгуулсан 7 удаагийн сургалт<br>- ЦХХЯ-аас зохион байгуулсан сургалт<br>- ЭМДЕГ-аас Удирдах ажилтны сургалт зөвлөгөөнд 2 удаа, ажилтнуудыг чадавхижуулах сургалтад мэргэжилтний хамт 1 удаа тус тус хамрагдлаа. | |
| 4.1.3 | Салбарын хууль тогтоомж, тогтоол шийдвэрийг сурталчлах, даатгалын орлого хамралтыг нэмэгдүүлэхэд чиглэсэн нээлттэй өдөрлөг,сургалт, сурталчилгааны бусад арга хэмжээг зохион байгуулна. | | Зохион байгуулсан арга хэмжээ, сургалтын тоо | Зохион байгуулсан арга хэмжээ-2, сургалтын тоо-3 | Сургалт, сурталчилгааны арга хэмжээг зохион байгуулж, тайлагнасан байна. | Сургалт, сурталчилгааны арга хэмжээг зохион байгуулж, тайлагнасан байна. | Аймгийн нийгмийн даатгалын хэлтэстэй хамтран Цагдаагийн газрын 32 ажилтан, ХАА-н салбарын газар тариалан эрхлэгч 22 ажилтан, аймгийн удирдах ажилтны шуурхай хуралд 80 гаруй дарга, эрхлэгч захирал нарт Эрүүл мэндийн даатгалын тухай хууль, Эрүүл мэндийн даатгал төлөлтийн ач холбогдлын талаар сургалт хийсэн. Мөн аймгийн Засаг даргын тамгын газраас зохион байгуулсан Булган аймагт тавтай морил формын хүрээнд нээлттэй хаалганы өдөрлөгт оролцож иргэдэд мэдээлэл өгсөн. Хэлтсийн пэйж хуудас болон фэйсбүүк хаягаар мэдээ мэдээллийг тухай бүр | 80 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | хэлтсийн албан хаагчид аймгийн хамгийн их дагагчтай 10 цахим хаягуудад өдөр бүр 2 албан хаагчид шэйр хийсэн | |
| 4.1.4 | Байгууллагын үйл ажиллагааны болон мэдээллийн ил тод байдлыг хангуулах ажлыг нутаг дэвсгэрийн хэмжээнд зохион байгуулж, иргэн-даатгуулагчид бодит мэдээ, мэдээлэл хүргэнэ. | | Иргэд, даатгуулагчдад хүргэсэн мэдээлэл, хандалтын тоо | Иргэд, даатгуулагчийн тоо- 2254 Хүргүүлсэн мэдээллийн тоо-12 | 1000-аас доошгүй иргэн даатгуулагчдад мэдээлэл хүргэсэн байна. | 1000-аас доошгүй иргэн даатгуулагчдад мэдээлэл хүргэсэн байна. | Гэрээт эрүүл мэндийн байгууллагуудад ЭМДЕГ-аас мэргэжилтнүүд ирж сургалт хийсэн. 2023 оны гэрээ дүгнэх 2024 оны гэрээ байгуулах үеэр 4-5 удаа цахимаар сургалтыг өгсөн. Байгууллагын үйл ажиллагааг ил тод байлгах ажлын хүрээнд гэрээт байгууллагууд болон иргэдэд эрүүл мэндийн даатгалын шимтгэл төлөтийн талаархи сургалтуудыг 9-10 удаа зохион байгуулж 1258 иргэн хувиараа хөдөлмөр эрхлэчид нарт сургалт сурталчилгааг хийж байна. Мөн ЭМДЕГ-аас энэ онд хэвлэгдэн ирсэн 12 нэр төрлийн брошур, хэвлэмэл хуудсыг гэрээт 49 гэрээт эрүүл мэндийн байгууллага болон аймаг сумын төвд үйл ажиллагаа явуулдаг зах, худалдааны төв, хүнс болон барилгын дэлгүүрүүдээр тараан байрлуулж иргэдэд мэдээлэл өгч ажиллалаа. Давхардсан тоогоор аймгийн хэмжээнд нийт | 70 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | 32,752 иргэнд мэдээлэл өгсөн байна. Хэлтсийн цахим хаяг болон ажилчдын фэсбүүк хаяг дээр ЭМДЕГ-аас оруулсан мэдээллийг шэйр хийн ажиллаж байна. | |
| 4.1.5 | *БГТ 4.1.8* Даатгуулагч-иргэд, гэрээт байгууллага, ажилтнуудаас сэтгэл ханамжийн судалгаа авах ажлыг зохион байгуулж, түүний мөрөөр зохих арга хэмжээг авч, нэгдсэн тайланг ерөнхий газарт хүргүүлнэ. | | Судалгаанд хамрагдсан иргэдийн тоо | 352 иргэн судалгаанд хамрагдсан | Сэтгэл ханамжийн судалгаа авч, нэгдсэн тайланг ерөнхий газарт хүргүүлсэн байна. | Сэтгэл ханамжийн судалгаа авч, нэгдсэн тайланг ерөнхий газарт хүргүүлсэн байна. | ЭМДЕГ-ын ОНХХ-ээс ирүүлсэн дотоод албан бичгийн дагуу гэрээт эрүүл мэндийн байгууллагуудаас сэтгэл ханамжийн судалгааг линкээр авсан. Мөн иргэдээс байгууллагын үйл ажиллагаатай холбоотойгоор 475 иргэнээс QR кодоор сэтгэл ханамжийн судалгааг авч ажиллалаа. Өнөөдрийн байдлаар аймгийн нийт иргэдийн 1,1 хувь хамрагдсан байна. | 60 |
| 4.1.6 | Иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн санал, хүсэлт, өргөдөл, гомдлыг хуулийн хугацаанд, үнэн зөв шийдвэрлэх ажлыг зохион байгуулж, шийдвэрлэлтэд хяналт тавьж тайлагнана. | | Албан бичиг, өргөдөл, гомдлын тоо, шийдвэрлэлтийн хувь | Албан бичиг, өргөдөл, гомдлын тоо 104, шийдвэрлэлт 100 хувь. | Албан бичиг, өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн мэдээг хагас, бүтэн жилээр нэгтгэн тайланг ерөнхий газарт хүргүүлсэн байна. | Албан бичиг, өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн мэдээг хагас, бүтэн жилээр нэгтгэн тайланг ерөнхий газарт хүргүүлсэн байна. | Энэ онд 74 иргэнээс төр хариуцах иргэн буюу хүүхдээ асарч байгаа иргэн, шинээр төрсөн хүүхдийн шимтгэл төлөлтийн өргөдлийг цахимаар болон цаасаар хүлээн авч ehealth программд оруулан ажилласан. 27 иргэнээс эрүүл мэндийн даатгалын шимтгэл төлөлт, илүү төлөлт, буруу төлөлтийн талаар ирсэн өргөдлийг хүлээн авч ЭМДЕГ-ын info@emd.gov.mn хаягаар хүргүүлэн өргөдлийг | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | шийдвэрлүүлсэн. | |
| 4.1.7 | Нэгжийн албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөөг баталж, хэрэгжилт, цаг бүртгэлд хяналт тавих, ажил үүргийг тэнцвэртэй, оновчтой хуваарилах, зөвлөн туслах, чиглүүлэх, өдөр тутмын удирдлагаар хангах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ. | | Албан хаагчийн ажлын гүйцэтгэлийн төлөвлөгөөний | Хэлтсийн мэргэжилтэний гүйцэтгэлийн төлөвлөгөөг байгуулж гүйцэтгэлийг хагас болон бүтэн жилээр дүгнэж ЭМДЕГ-т хүргүүлэн ажилласан. | Гүйцэтгэлийн төлөвлөгөө байгуулж, ажлын гүйцэтгэл, үр дүнг хагас, бүтэн жилээр үнэлж, дүгнэсэн байна. | Гүйцэтгэлийн төлөвлөгөө байгуулж, ажлын гүйцэтгэл, үр дүнг хагас, бүтэн жилээр үнэлж, дүгнэсэн байна. | Нэгжийн албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулан ЭМДЕГ-н даргаар батлуулан ажиллаж байна. Мөн өдөр бүр цагийн бүртгэлд хяналт хийх, сар бүр хийх ажлын төлөвлөгөө гарган баталж өдөр тутмын удирдлагаар хангаж ажиллаж байна. Мөн долоо хоног бүр удирдах ажилтны шуурхай хурлын дараа хэлтсийн ажлын хурлыг зохион байгуулж үүрэг даалгавар өгч биелэлтийг хангуулан ажиллаж байна. | 90 |
| 4.1.8 | Албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааг стандарт, зааврын дагуу явуулж, архивын нэгж бүрдүүлж, ЭМДЕГ-ын архивт хугацаанд хүлээлгэж өгнө. | | Бүрдүүлсэн архивын нэгжийн тоо | 2023 онд 2021, 2022 оны нийт 105 хадгаламжийн нэгж хүргүүлсэн | Албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааг стандарт, зааврын дагуу явуулж, архивын нэгж бүрдүүлсэн байна | Албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааг стандарт, зааврын дагуу явуулж, архивын нэгж бүрдүүлсэн байна | 2023 оны Эрүүл мэндийн даатгалын сангийн баримтыг үдэж цэглэн 37 архивын нэгж үүсгэн ЭМДЕГ-ын архивт 2024 оны 11 сард хүлээлгэн өгөхөд бэлэн болгосон. | 100 |
| 4.1.9 | Даргын зөвлөлийн болон шуурхай хуралдаан, цаг үеийн шинжтэй удирдлагаас | | Хугацаанд нь тайлагнасан үүрэг даалгаврын тоо, хэрэгжилтийн | Үүрэг даалгаврын хэрэгжилт 2023 онд 80 хувь | Цаг үеийн шинжтэй удирдлагаас өгөгдсөн үүрэг даалгаврын хэрэгжилтийг | Цаг үеийн шинжтэй удирдлагаас өгөгдсөн үүрэг даалгаврын хэрэгжилтийг | Даргын зөвлөлийн болон шуурхай хуралдаанд долоо хоног бүрийн мягмар гаригт оролцон өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг гарган тамгын газарт | 90 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | өгөгдсөн үүрэг даалгаврын хэрэгжилтийг хангаж, биелэлтийг хугацаанд нь үнэн зөвөөр тайлагнана. | | хувь. | | хангаж, биелэлтийг хугацаанд нь үнэн зөвөөр тайлагнасан байна. | хангаж, биелэлтийг хугацаанд нь үнэн зөвөөр тайлагнасан байна. | хүргүүлэн ажиллаж байна. Өнөөдрийн байдлаар байнга хэрэгжүүлэх үүрэг даалгаврын биелэлт 91 хувьтай, үүрэг даалгаврын биелэлт 85 хувьтай хэрэгжиж байна. | |

*Төлөвлөгөөг үнэлсэн:*
ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ХАВСРАН ГҮЙЦЭТГЭГЧ, ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА

***Төсвийн шууд захирагч***
.......................... / М.НАРМАНДАХ /
2024.12.16

*Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн:*
ДОТООД АУДИТ, ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ
ҮНЭЛГЭЭНИЙ ГАЗРЫН ДАРГА

***Нэгжийн дарга***
.......................... / Б.ОЮУНЦЭЦЭГ /
2024.12.16

УЖА0067
6263305
1118156030

*Тайлагнасан:*
БУЛГАН АЙМГИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН
ДААТГАЛЫН ХЭЛТСИЙН ДАРГА

***Нэгжийн дарга***
.......................... / Б.АРИУНБОЛД /
..........................